



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 30 өдөр

Дугаар А/870

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Инновацийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.1.2, 11.1.3., 11.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.4, 2.4.1-д тусгагдсан зорилтуудын хэрэгжилтийг хангах зорилгоор ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн, тодорхой тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн инновацийн төсөл сонгон шалгаруулах ажлын хэсгийг хавсралтаар баталсугай.

2. “Инновацийн төсөлд аймгийн Засаг даргын нэрэмжит тэтгэлэг олгох журам”-ыг холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд боловсруулж, 2021 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Засаг даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, батлуулахыг ажлын хэсэг /Д.Энхболд/-т үүрэг болгосугай.


3. Инновацийн төслийн сонгон шалгаруулалтыг журмын дагуу зохион байгуулахыг ажлын хэсэг /Д.Энхболд/-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Б ДҮГЭРЖАВ

Аймгийн Засаг даргын 2020 оны  
12 дугаар сарын 30-ны өдрийн  
А/870 дугаар захирамжийн хавсралт



## АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: Д.Энхболд - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

Гишүүд: Ч.Багдал - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга

Б.Баярсүх - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Н.Ганзориг - Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга

Нарийн бичгийн дарга: Д.Ариунбилэг- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтсийн дарга

-оОо-